



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2007 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Даатгалын тухай хуулийн 14.2.20, 49.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:

1. “Ердийн даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлох
заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд
үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ЕРДИЙН ДААТГАЛЫН БОЛОН ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОДОРХОЙЛОХ ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын Даатгалын тухай хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани (цаашид даатгагч гэх)-ийн эрхлэх ердийн даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлоход энэ зааврын зорилго оршино.

1.2. Ердийн даатгагч нь Монгол Улсад болон гадаад улсад гагцхүү ердийн даатгалын үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлнэ.

1.3. Даатгалын тухай хуулийн 16.1 дэх заалтын дагуу дор дурдсанаас бусад этгээд Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид Хороо гэх) олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

1.3.1. Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасан даатгагчтай гэрээ байгуулан давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд;

1.3.2. Даатгалын тухай хуулийн 17.2 дахь заалтад заасан гадаад даатгагч тухайлбал, Ллойдын андеррайтерын холбоонд багтдаг даатгагч.

ХОЁР. ЕРДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. "Ердийн даатгалын үйл ажиллагаа" гэж ердийн даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг ойлгоно. Ердийн даатгалын гэрээний үргэлжлэх хугацаа 1 жил хүртэл байна.

2.2. Ердийн даатгагч нь урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж үл болно.

2.3. Ердийн даатгалын үйл ажиллагаанд дараах үйл ажиллагааг хамааруулна:

2.3.1. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон ердийн даатгалын хэлбэрт хамаарагдах даатгалын бүтээгдэхүүний гэрээ болон баталгаа боловсруулж гаргах; [Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 17 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

2.3.2. Монгол Улсын Иргэний хуулийн 431 дүгээр зүйлд заасны дагуу даатгалын гэрээ байгуулах, гэрээг сунгах, өөрчлөх;

2.3.3. Даатгалын гэрээг бусдад шилжүүлэх, цуцлах;

2.3.4. Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу даатгалын нөхөн төлбөр төлөх;

2.3.5. Даатгалын эрсдэлийн болон хохирлын тойм үнэлгээ хийх;

2.3.6. Хорооноос баталсан "Даатгалын нөөц сан бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам"-ын дагуу даатгалын нөөцийн сан байгуулах;

2.3.7. Даатгалын хураамж тооцох түүнтэй холбоотой аливаа судалгаа хийх;

2.3.8. Даатгалын хэлбэр бүрээр журам боловсруулах;

2.3.9. Даатгалын компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан мэдээ гаргах зэрэг даатгалын үндсэн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа явуулах.

ГУРАВ. ЕРДИЙН ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Даатгагчийн дараах үйл ажиллагааг ердийн даатгалтай холбоотой үйл ажиллагаанд хамааруулна:

3.1.1. Хорооноос баталж гаргасан "Даатгагчийн дүрмийн болон нөөцийн сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага"-д заасан хөрөнгө оруулалтын дараах үйл ажиллагаа:

3.1.1.1. Банкинд мөнгөн хөрөнгө хадгалуулах;

3.1.1.2. Банкны харилцах дансанд мөнгөн хөрөнгө байршуулах;

3.1.1.3. Засгийн газрын өрийн бичиг худалдан авах;

3.1.1.4. Орон нутгийн засаг захиргааны бонд худалдан авах;

3.1.1.5. Компанийн бонд худалдан авах;

3.1.1.6. Түрээсийн үйл ажиллагаа явуулах;

3.1.1.7. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах;

3.1.1.8. Банкны хадгаламжийн сертификат худалдаж авах;

3.1.1.9. Богино хугацаат зээл олгох;

- 3.1.1.10. Үл хөдлөх хөрөнгө худалдан авах.
- 3.1.2. Энэ журмын 3.1.1-д заасан хөрөнгө оруулалтыг удирдах, захиран зарцуулах;
- 3.1.3. Даатгалын тухай хуулийн 22.1 дэх заалтын шаардлагад нийцсэн зээл авах;
- 3.1.4. Даатгалын эрсдэлээ давхар даатгуулах, түүнтэй холбоотой үүсч болох бусад үйл ажиллагаа явуулах;
- 3.1.5. Даатгалын салбар, төлөөлөгчийн газар нээж, ажиллуулах;
- 3.1.6. Даатгалын зөвлөгөө, сургалт явуулах;
- 3.1.7. Даатгалын компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэхтэй холбоотой үйл ажиллагаа явуулах;
- 3.1.8. Даатгалын компанийн байрны засвар үйлчилгээ хийх, түүнийг худалдах, худалдан авах;
- 3.1.9. Даатгалын тухай хуулийн 58 дугаар зүйлд зааснаас бусад даатгалын зар сурталчилгаа явуулах;
- 3.1.10. Холбогдох хууль, тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа эрхлэх.
- 3.2. Дараахь үйл ажиллагаа нь даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанд хамаарахгүй:
 - 3.2.1. Нийгмийн даатгалын болон иргэний эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа;
 - 3.2.2. Даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа;
 - 3.2.3. Даатгалын аудитын үйл ажиллагаа.

ДӨРӨВ. БУСАД

4.1 Даатгалын тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасныг зөрчсөн буюу энэ зааврын 3.1-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхэлсэн даатгагчид Даатгалын тухай хуулийн 83.1.19 д заасны дагуу хариуцлага тооцно.